



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/28

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын “Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай” 2022 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмнө нь газар өмчилсөн 1 (нэг) иргэний газрын хэмжээг кадастрын зураглалын дагуу өөрчилж, хавсралтад заасны дагуу өмчлүүлсүгэй.

2. Өөрчилсөн газрын хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу газар дээр нь тэмдэгжүүлж, газрын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулан, газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/78 дугаар захирамжийн тухайн иргэнтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
 дугаар сарын 15-ны/ний өдрийн
 дугаар захирамжийн хавсралт



ДУНДЫН ӨМЧЛӨГЧӨӨС ТАТГАЛЗАЖ, НЭГ УДАА ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ГАЗАР
 ӨМЧЛӨХ ЭРХЭЭ СЭРГЭЭЛГЭСЭН ИРГЭНИЙ НЭР

Д/Д	Иргэний ургийн овог	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршлын хаяг			Хасалт хийгдсэн иргэдийн нэрс			Засаг даргын өмнөх хүчингүй болсон шийдвэрийн дугаар
							Баг хороо	Гудамж хороолол	Байр хашаа хаалганы дугаар	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Хар сүрэг	Ганбат	Цэрэнлхам	ГЮ95071824	6308001152	Гэр бүлийн хэрэгцээнд	3	Зүүн агуйт-10	1017	Мягмарсүрэн	Ганбат	ГЮ65081931	2005-04-19-ны 86 дугаар захирамжийн Г.Цэрэнлхамт
										Цэдэндамба	Соёл	ГЮ66032569	
										Ганбат	Цэнд	ГЮ92021114	